

“Боловсролыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн 2017 оны хэрэгжилтийн талаар

№	Төлөвлөгдсөн арга хэмжээ	Хэрэгжилт	Хэрэгжилт ийн хувь
Зорилт-1.1. Багш, суралцагчдад эрүүл аюулгүй орчинд ажиллаж суралцах нөхцөлийг бүрдүүлэх			100 %
1	Сургуулийн цайны газар,цэцэрлэг, дотуур байрны гал тогооны тоног төхөөрөмжийг хүчин чадлаар ажиллуулахын тулд 380В-ын шугамд холбох асуудлыг судлах	Аймгийн ИТХ-аас сургуулиудаас ирүүлсэн судалгааны дагуу 20.0 сая төгрөгийг шийдвэрлэсэн бөгөөд Өндөрхангай сургууль 4.0 сая, Цагаанхайрхан сургууль 4.0 сая, Тариалан сургууль 3.0 сая, Тэс сургууль 4.0, сая Улаангом 6-р цэцэрлэг 3.0 сая, Улаангом 10-р цэцэрлэгт 2.0 сая төгрөг хуваарилан цахилгааны асуудлыг шийдвэрлэсэн.	100%
2	Сургуулийн цайны газарт дагаж мөрдөх стандартыг сайжруулах	Сургуулийн цайны газрын чанар стандартыг сайжруулах, Эрүүл мэндийн сайдын 2007 оны 06 сарын 04ны өдрийн 207 тоот тушаалын 3-р хавсралтаар батлагдсан “Тусгай хоолны дэглэмтэй хүн, цэцэрлэг хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан хоол үйлчилгээнд хориглох хоол хүнсний түүхий эд, хүнсний бүтээгдэхүүн”-нд хориглосон 25 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг худалдаалахгүй байх талаарх заавар зөвлөгөө, хяналт үнэлгээг аймгийн төвийн сургуулиудад МХГ, ЭМГ, БСУГ-ийн хамтарсан багаар ажиллаж зохих журмын дагуу шаардлага хүргүүлэн ажилласан.	100%
3	<i>Дотуур байрны багш, сургууль, цэцэрлэгийн эмч, нийгмийн ажилтан нарыг НҮЭМ сургалт, бусад сургалтад хамруулах, чадваржуулах</i>	Аймгийн ЭМГ, БСУГ, Данида төсөлтэй хамтран “Эрүүл залуус – Эрүүл ирээдүй” дэмжээ тэмцээнийг Улаангом суманд үйл ажиллагаа явуулж байгаа 6 сургууль, Улаангом коллеж, хөдөлмөрийн дээд сургуулиудын дунд зохион байгуулсан. 1-р байрт Цогцолбор 1-р сургуулийн баг 2-р байр Улаангом Политехник коллеж 3-р байр цогцолбор 2-р сургуулийн багууд тус тус шалгарсан. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн их эмчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг загварыг нийт сургууль, цэцэрлэгийн эмч нараар хэлэлцүүлж загварын төсөлд саналаа хүргэсэн. 2017 оны 05-р сарын 22,23ны өдрүүдэд АЗДТГ-ын НБХ-ээс зохион байгуулсан Эмч нарын сургалтад сургууль цэцэрлэгийн эмч нарыг хамруулсан.	100%
4	<i>ЕБС-ийн сурагчдад эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах</i>	Аймгийн хэмжээнд 26 сургагч сурагч ажиллаж байна. 2017онд Эрүүл мэндийн газрын дэргэдэх “Өсвөр үе ирээдүйн босго төвөөс” нэмэлтээр 70 сургагч сурагч бэлтгэж ЕБС-ийн сурагчдад эрүүл мэндийн боловсрол олгох, халдварт өвчлөлийг бууруулах ажлыг үе тэнгийн сурагчдыг ашиглан нөлөөллийн аргаар сургалтыг явуулж байна.	100%
5	<i>“Үе тэнгийн сургагч” сурагчдаар дамжуулан ЕБС-ийн сурагчдад сургалт зохион байгуулах</i>	Халдварт өвчлөлийг бууруулах зорилгоор сургууль, цэцэрлэгийн эмч, анги удирдсан багш нар нь эцэг эхийн хурал болон олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулахдаа эцэг эхчүүдэд халдварт болон халдварт өвчлөлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх зөвлөгөө мэдээлэл өгч боршур, гарын авлага 1000 гаруй ширхгийг тарааж ажиллаж байна.	100%
6.	<i>Халдварт өвчлөлийг сургууль, цэцэрлэгийн орчинд бууруулах ажлыг эцэг, эх олон нийттэй хамтран зохион байгуулах</i>	Хүйтний улирал эхэлж томуу томуу төст өвчин ихсэх магадлалтай байгаа учраас бүх сургууль, цэцэрлэг Эрүүл мэндийн яамнаас гаргасан “Ханиад томуунаас хэрхэн сэргийлэх”, “Цэгэн массаж хэрхэн хийх” зэрэг зөвлөмжийг http://www.mohs.mn/ хаягаас авч урьдчилан сэргийлэх сургалт явуулж, зөвлөгөө өгөх, сургууль, цэцэрлэг, дотуур байранд ариутгал халдваргүйтгэл хийх зэрэг үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж ажиллахыг зөвлөж сургуулиуд сурагчдын II улирлын хичээл эхлэхэд “Амны хаалт” /маск/ зүүлгэх, (3-4 ээлжийн байх) Амны хаалтаа тогтмол угааж ариутгаж хэрэглэх аяныг өрнүүлэн ажиллаж байна.	70%

7.	<i>Нэг хүүхэд –нэг удаа ОО цаас, гарын шингэн саван” аяныг хэрэгжүүлэх</i>	Гар угаах орчин нөхцөл, цаг хугацааны хувьд бололцоо муу, хүүхдүүд нойтон сальфетка хэрэглэж байгаа боловч зарим хүүхдэд харшил өгөх гар нь сайрдах сөрөг нөлөө гарч байна. Зарим хүүхэд эдийн засгийн бололцоогүйгээс сальфетка хэрэглэж чадахгүй байна. Энэ тал дээр сургуулиуд эцэг эхтэйгээ хамтран сургуулийн ОО-д гар угаах шингэн саван, ОО-ын цаасны асуудлыг шийдэж чадсанаар сурагчдын гарын ариун цэврээ сахих, дадал хэвшилд эерэгээр нөлөөлж байна. / Цогцолбор 1 сургуулийн санаачилга/	70%
Зорилт 1. 2 Сургалтын орчинг сайжруулах			100%
	Сургуулийн номын сангуудыг стандартад нийцүүлэн тохижуулж, хүүхдийн нас бие сэтгэхүйн онцлогт тохирсон уншлагын номоор тасралтгүй хангах	2017 онд БСШУСЯ-наас 22.0 сая төгрөг, Туркийн ТИКА төслөөс 56.3 сая төгрөг нийт 78.3 сая төгрөгийн номыг сум, сургуулийн номын санд нийлүүлсэн байна. Иргэд, аж ахуй нэгж байгууллагуудаас сургуулийн номын санд нийт 12.6 сая төгрөгийн өртөг бүхий 3219 ш ном нийлүүлсэн байна.	100%
	Сургууль тус бүр өөрийн орон нутгийн онцлогт тохирсон хөдөлмөр амралтын “ Гэр зуслан ” – г зохион байгуулах	2016-2017 оны хичээлийн жилд аймгийн ЕБ-ын 15 сургууль хөдөлмөр амралтын “Гэр зуслан”-г ажиллуулж нийт 550 гаруй хүүхдийг хамруулсан байна. Хөдөлмөр амралтын зусланд хүүхдүүд амарснаар амьдрах ухаан, ардын ёс уламжлалд суралцах, төрөл бүрийн сургалтад хамрагдах, байгаль хамгаалах, хайрлах дадал хэвшилд суралцах зэрэг олон эерэг үр дүнгүүд гарсан байна. Хөдөлмөр зуслан зохион байгуулсан сургуулиудаас Өндөрхангай, Ховд, Бөхмөрөн, Сагил сумын сургуулийн зохион байгуулсан зуслангууд үр дүн, цар хүрээ, оролцооны хувьд бусдаас онцлог байсан байна.	100%
Зорилт - 1.3. Сургууль, цэцэрлэг, дотуур байрны цэвэр ус, ариун цэврийн байгууламжийг стандартад нийцүүлэн шинэчлэн, тохижуулах			70%
1.	Аймгийн ЕБ-ын 10 сургуулийн 16 дотуур байрны ОО болон ариун цэврийн байгууламжийг АХБ-ны санхүүжилтээр 2017-2018 онд шинэчлэх, үлдсэн 3 дотуур байрын ариун цэвэр ОО асуудлыг ОНХС-аар дамжуулан стандартад нийцүүлэн шийдвэрлэх	2017 оны 2-3-р сард “Баруун бүсийн дотуур байрын орчин нөхцөлийг сайжруулах” төслийн судалгааны баг, АХБ-ны төслийн судалгааны багтай хамтран төсөл хэрэгжих 10 сумын 10 дотуур байр болон аймгийн 23 сургуулийн 30 дотуур байрын орчин нөхцөлийн нарийвчилсан судалгааг авч БСШУСЯ-нд нэгтгэн хүргүүлсэн. 10 сумын 10 дотуур байрны барилгын засварын ажлын зургийг “ Татах хүч” ХХК хийж байна. Энэ ондоо багтааж зургаа хийж дуусгаад 2018 оны 1 сард барилга засварын тендер зарлагдана.	40%
2.	<i>Сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн орчны стандартыг мөрдүүлэх талаар хамтарсан сургалтуудыг зохион байгуулах</i>	Цэцэрлэгийн гадна тоглоомын талбайг орчны стандартад нийцсэн шинэ тоглоомоор тохижуулах ажлыг ихэнх цэцэрлэгүүд төлөвлөсөн байна. Ялангуяа Улаангом сумын 3,4,5-р цэцэрлэг, Тариалан, Өмнөговь, Өндөрхангай, Завхан сумууд гадна талбайг стандартад нийцсэн тоглоомоор орчин бүрдүүлж бүтээлч санаачилгатай ажиллаа. Улаангом сумын 5,6-р цэцэрлэгүүд хүүхдийн ариун цэврийн өрөөний тохижилтод илүү анхаарч эрүүл аюулгүй байдлыг хангах, стандартад нийцсэн загвар орчин бүрдүүлэн аймгийн хэмжээнд туршлагаа түгээн ажиллаж байна.	70%
Зорилт-1.4: Удирдах ажилтныг хөгжүүлэх, туршлага,солилцох, сургалт сурталчилгааг зохион байгуулах			100%
1	<i>НБХ, БСУГ-ын дарга мэргэжилтэн, сургуулийн захирлуудад “Туршлага судлах” ажлыг зохион байгуулах</i>	2017 оны 9 сарын 11-15-нд Баруунтуруун, Ховд суманд Боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагын туршлага солилцох, зөвлөлдөх уулзалтыг зохион байгууллаа. Энэхүү уулзалтад нийт 19 сумын Боловсрол, соёл, эрүүл мэндийн 80 гаруй байгууллагын 160 гаруй удирдах ажилтан оролцож өөрийн байгууллагын хийж хэрэгжүүлж туршсан 350 гаруй туршлага, санал санаачилгаа танилцуулсан бөгөөд нийт 25 туршлага, бүтээлч санааг баруун, зүүн бүсийн түвшинд энэ хичээлийн жилд бүх байгууллагууд туршин хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн	100%

		<p>билээ.</p> <p>АЗДТГ-аас удирдах ажилтны туршлага, мэдлэг, боловсрол мэргэшлийг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулсан үйл ажиллагаанд 2017 оны 03 сарын 22-28-нд Тайванд ЕБС-ын 11 захирал туршлага судлах сургалтад, ОХУ-ын Кызыл хотноо зохион байгуулагдсан фестивалд 1 мэргэжилтэн, ОХУ-ын Тува улсын Дээд хурал, Увс аймгийн ИТХ-ын хамтын ажиллагааны орос хэлний “Я люблю русский язык” танин мэдэхүйн уралдааныг 2017 оны 3-р сарын 23 өдөр зохион байгуулсан, ОХУ-ын Тува улсын Дээд Хурлын /Парламентын/ орлогч дарга, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга болон төлөөлөгчид, мөн тус улсын БШУЯамны сайдын орлогч, орос хэлний улсын байцаагч Хардикова Елена Викторовна болон бусад төлөөлөгчид Улаангом суманд ажиллан АЗДТГ-ын НБХ-ийн дарга С.Амраа, БСУГ-ын дарга С.Дашням, нартай хамтын ажиллагааны хүрээнд хийгдэх ажлын талаар санал солилцон ОХУ-ын төлөөлөгчид Цогцолбор 1-р сургууль болон Цогцолбор 2-р сургуулийн үйл ажиллагаатай нь танилцан ажилласан, аймгийн Төв номын сан дээр АНУ-ын элчин сайдын яамны дэмжлэгээр Америк соёл-мэдээллийн төв, Цогцолбор 2-р сургуулийн байранд Оросын шинжлэх ухаан, соёлын төвийн Увс аймгийн салбар төв тус тус байгуулагдсан, сурагч солилцоо хөтөлбөрийн хүрээнд Япон улсад 2 сурагч, Франц улсад 1 сурагч тус тус хамрагдан гадаад хамтын ажиллагааг эрчимжүүлэн ажиллалаа. Тогтвортой хөгжлийн боловсрол олгох сургалтад БСУГ-ын мэргэжилтнүүд 2 удаа, 50 багш, сургалтын менежер нар Ховд аймагт сургалтад хамрагдлаа.</p>	
2.	“Эцэг, эхэд” илгээх захидал хүргэх ажлыг зохион байгуулах	<p>Боловсрол, соёл урлагийн газраас санаачлан “Багш сурагчийн гэрт” аяныг зохион байгуулсан ард иргэдийн хүсэн хүлээсэн сургууль эцэг эх багш нарын үйл ажиллагаа оролцоо нэмэгдсэн ажлын нэг боллоо. Уг аянд аймгийн ЕБ-ын 30 сургууль, 31 цэцэрлэг оролцсон байна. Аймгийн хэмжээнд нийт сургуулийн 726 багш 7103 өрх буюу 9885 сурагч, цэцэрлэгийн 259 багш 3083 өрх буюу 3403 хүүхдийн гэрээр очиж эцэг эхийн санал бодлыг сонсон, аяны хүрээнд 985 багш 10186 өрх буюу 13288 хүүхэдтэй хамтран ажиллаж, аймгийн төвийн сургууль, цэцэрлэгүүд орон нутгийн МВС, УВС телевизээр нийт 18шууд нэвтрүүлэг буюу “Багш-сурагчийн гэрт” аян хэрхэн явагдаж байгаа талаар мэдээ мэдээлэл, сурвалжилга өгч, эцэг эхчүүдийн санал сэтгэгдлийг дамжуулсан байна.</p>	100%
3.	Бүх нийтээрээ гэр бүлийн уншлагын цагтай болгох ажлыг зохион байгуулах	<p>“Аз жаргалтай гэр бүлийн нууц” сэдвийн дор эцэг эхэд зориулсан “Хүүхдийн буруу юу”, “Ээж ээ би таныг сонсож байна”, “Хүүхдийг хэрхэн муу хүмүүжүүлдэг вэ?”, “Би хүүхдээ ойлгохоо байлаа”, “Бид хүүхдээ залуу нас ба амьдралд бэлдэж байна”, “Хүүхдийн хүмүүжлийн талаар асуулт хариулт”, “Хүүхдэд өөртөө итгэх итгэлийг хайрын хэлээр төлөвшүүлэх”, “Хүүхдийн хүмүүжлийг зургаар”, “Боловсрол гэр бүлээс эхэлдэг” номын 9 багц сэдвээр сургалтын материал бэлтгэн Баруунтуруун сумын 126, Цогцолбор 1-р сургуулийн 26, бүгд 152 эцэг эхэд тус сургалтыг зохион байгууллаа.</p>	100%
4.	Сургууль, цэцэрлэг бүр өөрийн ажлаа сурталчилсан сонинтой болох	<p>Бөхмөрөн, Цагаанхайрхан, Ховд, Ахлах 4 сургуулиудын өөрийн ажлаа сурталчлах сонинтой болсон. Мөн ЕБС, цэцэрлэгүүд цахим мэдээллийн группүүдтэй болсон.</p>	40%
5.	Багш, сурагч, эцэг, эхийн сайн дурын үүсгэл санаачилгын ажлуудыг дэмжих	<ol style="list-style-type: none"> 1. Сургалтын орчин, тоног төхөөрөмжөө шинэчлэх зорилгоор Цагаанхайрхан, Өмнөговь, Баруунтуруун сумын сургуулиуд нийт 160 гаруй сая төгрөгийн 80 жижиг төсөл бэлтгэн төгсөгчид, ард иргэд, аж ахуй нэгжид хандан шийдвэрлүүлж чадсан. 2. Хөдөлмөр амралтын зусланг үр дүнтэй ажиллуулж, хүүхдийн амьдрах ухаан, ардын ёс уламжлалд сургах чиглэлд тодорхой ахиц дэвшил гарсан Бөхмөрөн, Өмнөговь сумын туршлага 3. ЭЕШ бэлтгэх чиглэлд Хяргас, Ховд, Ахлах 3-р сургуулийн туршлага, шинэ санаа 4. Хүүхдийн эх оронч, хариуцлагатай иргэн болгох, бахархал, хүмүүжил олгоход чиглэсэн “Боловсролын гэрчилгээ, үнэмлэх гардуулах ёслол” зэрэг олон чухал санааг дурдаж болохоор байна. 	100%

ХОЁР: Багшийн хөгжил “ дэд хөтөлбөрийн хүрээнд

Зорилт 2.1. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд чиглэсэн багшлах арга зүйд тулгамдаж байгаа асуудлыг судалж, шийдвэрлэхэд арга замыг тодорхойлон багш мэргэжил, ур чадвараа хөгжүүлэх нөхцөл, боломжийг судлах **100%**


1.	<p>Хэрэгцээнд тулгуурласан сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулах. Үүнд онолын сургалт /2017/, сэтгэл зүй ба хандлагын сургалт /2018 он/, мэдээлэл харилцааны технологийн сургалтуудыг /2019 / зохион байгуулах болно.</p>	<p>“БАГШИЙН ХӨГЖЛИЙН АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ” хэрэгцээнд тулгуурласан сургалт. Сургалтыг 2 үе шаттай зохион байгуулж, бага боловсролын 250 багш хамрагдаж арга зүй , ур чадвар онолын мэдлэгээ дээшлүүлсэн.</p> <p>1. Математик онол, арга зүй 2. Монгол хэлний онол арга зүй 3. Байгалийн ухааны онол туршилтууд</p> <p>Ээлжит хичээлийн төлөвлөлт, арга зүй гэсэн 4 өртөөгөөр сургалтыг дадлага ажил, лекц онол хосолсон хэлбэрээр зөвлөх багш нарын багаас бүрдсэн 15 багш удирдан чиглүүлж ажилласан.Сургалтын эцэст санал асуулга, онолын шалгалт авч нэгтгэсэн.</p> <p>Улсын төрөлжсөн олимпиадаас алт, мөнгө, хүрэл медальтай Т. Мөнхцэцэг, Р. Адьяа нар “Газарзүйн бодлого бодох аргачлал, олимпиадад бэлтгэх аргуудаар сургалтыг 2017 оны 11 сарын 6-8-ны өдрүүдэд зохион байгууллаа.</p>	100%
----	---	--	------



3.	<p>“Зөвлөх” мэргэжлийн зэрэгтэй багш нарын зөвлөл нь жилдээ 6-7 сургууль цэцэрлэгт хүрч ажиллана.</p>	<p>Монгол улсын зөвлөх багш Б.Тайван 2017 оны 10-12 сард монгол хэлний сургалтын чанар, үр дүнг сайжруулах чиглэлд Ховд, Бөхмөрөн, Өндөрхангай, Цагаанхайрхан, Завхан, Тариалан сумдад ажилласан.</p> <p>Ховд сумын ерөнхий боловсролын сургуулиас хүсэлт ирүүлсний дагуу Монгол улсын зөвлөх багш С.Наранпэл, Д.Төгөлдөр, Ж.Энхцэцэг нар 11 сарын 3-10-нд зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан байна.</p> <p>БСУГ-аас сургалтын чанар, элсэлтийн ерөнхий шалгалтын дүн оноогоор сүүлийн 2 жил хангалтгүй дүн үзүүлж буй Тэс, Зүүнговь, Өлгий, Тариалан, Наранбулаг суманд “Зөвлөх баг” ажиллуулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.</p>	100%
----	---	---	------

4.	<p>1-5 жил ажиллаж байгаа залуу багш нарын дунд ур чадварын уралдаан зохион байгуулж арга зүйн удирдлагаар хангана.</p>	<p>1. Аймгийн хэмжээнд цэцэрлэг, бага ангийн болон хими биологийн багш нарын дунд нийт 162 багш нарын дунд нийт 162 багш оролцсон “ХОСООР ЗААХ АРГА ЗҮЙ” ур чадварын уралдааныг зохион байгууллаа.</p> <p>2. СӨБ, бага, дундын залгамж холбоог сайжруулах зорилгоор харилцан туршлага солилцох, хамтарч хичээл бэлдэх, заах, арга туршлага солилцоххүрээнд ” Сургууль цэцэрлэгийн залгамж холбоо” өдөрлөг, “Нэг багш- Нэг хичээл”, “ Нэг ЗАН- Нэг сайн хичээл” зэрэг аян зарлан хамтран ажилладаг байгууллага сургууль, цэцэрлэгтэйгээ туршлага солилцох, иргэд, эцэг эх аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажилласан байна.</p> <p>ЕБС, СӨБ-д 1-5 жил ажилласан залуу багш нарын ур чадвар, илтгэлийн уралдааныг 2017 оны 10 сарын 19-20-нд Зүүнговь, Тариалан, Өлгий сумуудад бүсийн, 10 сарын 25-26-нд аймгийн шатыг зохион байгуулж бүсийн уралдаанд 120 гаруй багш 4 чиглэлээр, аймгийн уралдаан 24 багш оролцсон. Илтгэлийн уралдаан бүсийн</p>	100%
----	---	---	------

		шатанд нийт 65 илтгэл, аймгийн шатанд 9 илтгэл оролцож Цогцолбор 1-р сургуулийн багш У.Дүншиг тэргүүн байранд шалгаран улсын шатанд оролцох эрх авсан байна.	
5.	<i>Сайн хичээлийн сан бүрдүүлэх, багшлах арга зүйн чиглэлээр зөвлөмж боловсруулан сургууль цэцэрлэгүүдэд хүргэж түгээн дэлгэрүүлнэ. Багш удирдах ажилтан, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах.</i>	Математик,мэдээллийн технологи, физикийн136 багш нарын арга туршлагыг түгээх, хамтран суралцах зорилгоор “Нэг бүтээл-Нэг туршлага” аяныг 3 үе шаттай зохион байгуулж мэргэжлийн группээр дамжуулан солилцож ажилласан. 1-р шатанд Улаангом сумын багш нар 1 туршлагаа мэргэжлийн багш нарын цугларалтын үеэр бусдадаа ярьж санаа оноогоо солилцсон / 61 багш ярьсан бичлэгээр бусад багш нарт түгээсэн 2-р шатанд мэргэжлийн багш бүр мэргэжлийн группээр дамжуулан өөрийн 1 туршлагаа түгээсэн /77 багш оролцсон / 3-р шатанд 1 туршлагыг бүтээл болгож 10-р сард видео болон файлаар ирүүлж мэргэжлийн багш нарын арга туршлагын эмхтгэл хийхээр ажиллаж байна. Цогцолбор 1,2 –р сургуулийн багш Д.Батсүх, Р.Одгэрэл Н.Батгэрэл, Д.Даваадорж, Э.Гэрэлмаа, Р.Эрдэнэцэцэг нарын ажлын туршлага ,ЭЕШ бэлтгэх арга зүйг түгээн дэлгэрүүлж залуу багш нар суралцаж санаа авах зөвлөмж болгон түгээж байна	100%
Зорилт 2.2. Багш нарын мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах, түгээн дэлгэрүүлэх			100%
1.	<i>Олимпиад, уралдаанд тогтмол амжилт гаргасан багш сурагчдаа дэмжих, урамшуулах ажлыг зохион байгуулах</i>	2017 оны 03-р сарын 29-ний өдрөөс 04-р сарын 02 өдрүүдэд Увс аймгийн Улаангом суманд Улсын төрөлжсөн олимпиадын 2-ын давааг Цогцолбор 1-р сургууль, Цогцолбор 2-р сургууль, Ахлах 3-р сургууль, Ахлах 4-р сургууль, Улаангом политехник коллеж зэрэг сургуулиуд дээр амжилттай зохион байгууллаа. Олимпиадад 24 сургуулийн давхардсан тоогоор 1184 багш нар оролцлоо. Үүнд төрөлжсөн олимпиадад 642 багш, БСУГ-аас зохион байгуулдаг нэрэмжит олимпиадад 542 багш нар оролцсон байна. Улсын төрөлжсөн 3-ын давааны олимпиадад 47 багш,сурагч оролцсоноос алт-6, мөнгө-1, хүрэл-6 нийт 13 медаль хүртэж, сайхан амжилт гаргалаа.	100%
2.	<i>“Багш солилцоо” хөтөлбөр хэрэгжүүлэх, олон улсын төсөл хөтөлбөрийг судалж, багш нарыг хамруулах</i>	2017 оны 4-р сарын 17-29-нд ЗДТГ-ын урилгаар ОХУ-ын Томскийн УБИС-ийн хэлний бэлтгэл тэнхимийн эрхлэгч Елена Юрьевна Кошелева аймгийн “Орос хэлний төв”-д 14 хоног ажиллав. Тэрээр энэхүү хугацаанд Орос хэлний сургалтыг явуулсан ба сургалтад дунд ахлах ангийн 40 сурагч, насанд хүрэгчид 40, орос хэлний 15 багш орос хэл заах арга зүйн сургалтад тус тус амжилттай хамрагдлаа. БСШУСЯ-наас зохион байгуулж буй Япон, Солонгос улсад туршлага судлах сургалт аялалд 2017 оны 10,11-р саруудад СӨБ-ын 1 эрхлэгч, 1 мэргэжилтэн хамрагдана. 2017 оны 4-р сард Улаангом сумын 1,2-р цэцэрлэгийн 4 багш Абакан хотын 11, 19-р цэцэрлэгт туршлага судлан ажиллалаа.	100%
3.	<i>Олон улсын олимпиад, уралдаан тэмцээнд багш сурагчдыг дэмжиж оролцуулах, удирдлагаар хангаж ажиллах</i>	Тува улсын Кызыл хотод зохион байгуулагдсан залуу математикчдын олон улсын наадамд 2016 оны 11-р сарын 17-18 өдрүүдэд оролцлоо, Увс аймгаас БСУГ-ын мэргэжилтэн У. Төмөрхүү, Цогцолбор 2-р сургуулийн багш Р. Одгэрэл , Цогцолбор 1-р сургуулийн 6 сурагч , Цогцолбор 2-р сургуулийн 3 сурагч, Ахлах 3-р сургуулийн 1 нийт 7-р ангийн 5 сурагч, 8-р ангийн 5 сурагч баг болж мэндчилгээ, математик бидний амьдралд илтгэлийн уралдаан , математикийн тулаан гэсэн төрлөөр оролцож ТЭРГҮҮН байр эзэлсэн . Улаангом сумын сургуулиудын багш нарт Кызылд оролцсон баг үзүүлэх тэмцээнийг явуулсан.	100%
4.	<i>Багш сурагчдын төрөлжсөн олимпиад болон нэрэмжит олимпиадыг нээлттэй зохион байгуулж улсад гаргах амжилтыг ахиулна.</i>	2017 оны 03-р сарын 29-ний өдрөөс 04-р сарын 02 өдрүүдэд Увс аймгийн Улаангом суманд Улсын төрөлжсөн олимпиадын 2-ын давааг Цогцолбор 1-р сургууль, Цогцолбор 2-р сургууль, Ахлах 3-р сургууль, Ахлах 4-р сургууль, Улаангом политехник коллеж зэрэг сургуулиуд дээр амжилттай зохион байгууллаа. Олимпиадад 24 сургуулийн давхардсан тоогоор 1184 багш нар оролцлоо. Үүнд төрөлжсөн олимпиадад 642 багш, БСУГ-аас зохион байгуулдаг нэрэмжит олимпиадад 542 багш нар оролцсон байна.	100%



	Оролцсон багш, сурагчид	Гаргасан амжилт	Алт	Мөнгө	Хүрэл
Багш	18	8	4	0	4
12-р анги	19	5	2	1	2
11-р анги	2	0	0	0	0
10-р анги	1	0	0	0	0
9-р анги	7	0	0	0	0
Нийт	47	13	6	1	6

Зорилт -2.3. Багшийн хөгжлийг дэмжиж, сургалтын орчин бүрдүүлэх

100%

1.	Спортын бага наадмыг 6 төрлөөр сургууль, цэцэрлэгийн багш ажилчдын дунд 2 үе шаттайгаар зохион байгуулж, хамтран ажиллана.	2017 оны 9 сарын 29-31-нд Багш нарын спортын бага наадмыг багийн 5 төрлөөр зохион байгууллаа. Наадамд сагсан бөмбөг, гар бөмбөг, теннис, шатар, даам гэсэн гэсэн спортын 5 төрлөөр 123 багц медаль, 3 цомын төлөө 24 байгууллагын 300 гаруй тамирчид оролцов. Тэмцээний нийт шагналын сан 2.5 сая төгрөг байсан бөгөөд багийн нийлбэр дүнгээр 1-р байр Цогцолбор 1-р сургууль 2-р байр Цогцолбор 2-р сургууль 3-р байр Увс Эрдэм сургууль шалгарсан байна.	100%
2.	Багш нарын бага хурлыг эцэс эх, сурагч, багш төрийн ба төрийн бус байгууллага олон нийтийн оролцоон дээр тулгуурлан хэрэгцээ шаардлагад нийцүүлэн зохион байгуулахад аймаг орон нутгаас дэмжлэг авна	2017-2018 оны хичээлийн жилийн багш нарын бага хурлыг “Улсын хөгжил хүнээс, хүний хөгжил багшаас”, Багшийн хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлж уриатайгаар 8 сарын 25-нд зохион байгуулсан. Бага хуралд сумын засаг дарга, ЕБС-ийн захирал, сургалтын менежер, багш, цэцэрлэгийн эрхлэгч, багш, аймгийн засаг дарга, НБХ-ын дарга, мэргэжилтэн, БСУГ-ын мэргэжилтэн, Боловсролын хяналтын улсын байцаагч, орон нутаг дахь их, дээд сургуулийн удирдлага гэсэн нийт-300 гаруй төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулсан. Бага хурлаар 2016-2017 оны хичээлийн жилийн зорилтын биелэлт, 2017-2018 оны хичээлийн жилийн зорилтын төслийг хэлэлцэж аймгийн боловсролын салбарын тулгамдсан асуудал болох сургалтын стандарт хангалт, элсэлтийн ерөнхий шалгалтын аймгийн дүнг ахиулах чиглэлд тодорхой санал, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний талаар ярилцсан.	100%
3.	Оны шилдэг багш, сургууль, цэцэрлэгийн хамт олныг шалгуур үзүүлэлтийн дагуу	Оны шилдэг багш, сургууль, цэцэрлэгийг шагнаж урамшуулах шалгуур үзүүлэлтийг боловсруулан БСУГ-ын мэргэжилтэн, сургуулийн цэцэрлэгийн захирал, эрхлэгчийг хамруулан хэлэлцүүлэг явуулж санал дүгнэлтийг авсан.	70%

	<p>үнэлж шагнаж урамшуулдаг шагналын санг бүрдүүлэхэд аймаг, орон нутгаас дэмжлэг авна.</p>	<p>Тэргүүний багш, сургууль, цэцэрлэгийг урамшуулахдаа улсын шагналын 50%-аар тооцож шагнадаг байх, шагналын санг аймаг, сумын ОНХС-ын хөрөнгөнд тусгадаг байх саналууд гарсан бөгөөд энэ чиглэлд тодорхой журам боловсруулахаар ажиллаж байна.</p>	
<p>ГУРАВ: ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ” дэд хөтөлбөр</p>			
<p>Зорилт- 3-1. Хүүхдийг харилцааны зөв дадал хэвшилтэй, иргэн болгон төлөвшүүлэх</p>			<p>100%</p>
<p>1.</p>	<p>Хүүхдийн чуулганыг 2 жилд 1 удаа зохион байгуулах</p>	<p>ЦООХОР ИРВЭСИЙН ЭХ НУТАГ – 2017” БАРУУН БҮСИЙН ХҮҮХДИЙН АРГА ХЭМЖЭЭ БОЛЛОО Увс аймгийн ЗДТГ, Дэлхийн байгаль хамгаалах сан, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Боловсрол соёл урлагийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Увс нуур ай савын захиргаа хамтран “ЦООХОР ИРВЭСИЙН ЭХ НУТАГ – 2017” баруун бүсийн арга хэмжээг өнөөдөр Улаангом хотноо зохион байгууллаа. Тус арга хэмжээнд Увс, Ховд, Говь-Алтай, Баян-Өлгий аймаг, ОХУ-ын Тува улсын Кызыл хотын 210 гаруй хүүхэд, 21 багш, 16 мэргэжилтэн оролцлоо. “ЦООХОР ИРВЭСИЙН ЭХ НУТАГ – 2017” БАРУУН БҮСИЙН ХҮҮХДИЙН АРГА ХЭМЖЭЭ нь</p> <ul style="list-style-type: none"> - Гар зургийн үзэсгэлэн, - Бүтээлийн үзэсгэлэн - Цоохор ирвэсийн багт наадам, жүжигчилсэн тоглолт - Талбайн зургийн уралдаан - Цахим хичээлийн уралдаан <p>Шторкны уралдаан зэргээр уралдааныг зохион байгуулсан.</p>	<p>100%</p>
<p>2.</p>	<p>Зуны цугларалт-сургалт зохион байгуулж удирдах ХӨУБ-ын удирдагч багш, сурагчдыг чадваржуулах сургалт зохион байгуулах.</p>	<p>-2017 оны 7 сарын 27-8 сарын 2-нд олон улсын Найрамдал зусланд зохион байгуулагдсан Ази-Номхон далайн скаутын 31-р жемборид манай аймгаас 11-17 насны 130 скаут, 6-10 насны 30 каб нийт 160 хүүхэд, 15 багшийн бүрэлдэхүүнтэй томоохон баг оролцсон бөгөөд энэхүү үйл ажиллагаанд аймгаа төлөөлөн оролцсон хүүхдүүдийн зардлын тодорхой хэсгийг АЗДТГ-аас шийдвэрлээд байна. Цаашид орон нутагт байгаа скаутын салаа, бүлгэмүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулах, удирдагч багш нарыг сургах, дадлагажуулах, бүсийн болон үндэсний цугларалтад аймгийн бүрэлдэхүүнийг тогтмол оролцуулж байх, аймаг, сумын хэмжээний майхан цугларалтуудыг үе шаттайгаар зохион байгуулах чиглэлд тодорхой ажлуудыг зохион байгуулах шаардлагатай байна. Энэхүү олон улсын жемборид Цогцолбор 1-р сургууль 9 салаа, Ахлах 3, Цогцолбор 1, Тариалан, Хяргас, Ховд сумын сургууль 1 салаа, Малчин, Наранбулаг, Сагил, Зүүнхангай, Өлгий, Завхан сумын сургууль 1-6 хүүхдийн бүрэлдэхүүнтэй төлөөлөл оролцуулж идэвх санаачилга гарган ажилласан байна.</p>	<p>100%</p>
<p>3.</p>	<p>Хэл яриа хөгжүүлэх чиглэлээр сургууль бүрд сургагч багш бэлтгэх Хэл яриа хөгжүүлэх гарын авлага, DVD бэлтгэн сургуулиудад хүргүүлэх</p>	<p>1 дүгээр ангийн багш нарт зориулсан “Уншуулж сургах арга зүй-Хүүхэд нэг бүрийн хөгжилд” Нэгдүгээр ангид хичээл заах багш нарын сургалтыг 08.23-24 өдрүүдэд зохион байгуулж нийт 75 багшийн арга зүй ур чадварыг дээшлүүлсэн. Бэлтгэл хөтөлбөрийн шинэчлэл түүнийг хэрхэн хэрэгжүүлэх чадамжийг бүрдүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Авиа үсэг заах арга зүй ➤ Уншуулж сургах арга зүй ➤ Авианы задлаг нийлэг арга зүй <p>Бага боловсролын 284 бүлгийн 6701 сурагч хамрагдсан. Аймгийн дундаж унших чадвар -76,4 20-оос доош үг уншдаг -286 суралцагч 50-доош үг уншдаг -1590 сурагч 76 дээш үг уншдаг – 3749 буюу нийт 46,9% эзэлж байна.</p>	<p>100%</p>

		<ul style="list-style-type: none"> ➤ Ярих чадварын хувьд – 64,8% ➤ Бичих чадварын түвшин -87% <p>Нэг бүтэн өгүүлбэр бичихэд хэрэглэж буй үгийн дундаж -7,4 үг байна.2016-2017 оны хичээлийн жилийн 6-р зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд багш нар сургууль бүр шинэлэг ажлыг хийж байгаа нь эндээс харагдаж байна.</p> <p>Цэцэрлэг бүр хүүхдийн ярих чадварыг хөгжүүлэх ажлын хүрээнд “Уран уншигч” “Үлгэрийн баатрууд амилсан нь” тоглолт, үзүүлэх ажлыг зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд 890 гаруй хүүхэд оролцож Ширээний хүүхэлдэй, Хуруун хүүхэлдэй, Хормогчин хүүхэлдэй, дүрийн тоглолтоор эцэг эх, найз нөхдөдөө тоглож үзүүлсэн байна. Энэхүү ажил нь хүүхэд бүр өөртөө итгэлтэйгээр санаа бодлоо илэрхийлдэг, хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх, үгийн баялгаа нэмэгдүүлсэн үр дүнтэй ажлуудын нэг байлаа</p>	
4.	Хүүхдийн хэл яриа, ярьж илтгэх чадварыг хөгжүүлэх хөтөлбөрийг олон нийтэд сурталчлах.	<p>“Сурагчдыг эх хэлээрээ алдаагүй бичдэг, үгийн арвин баялаг сантай яруу сайхнаар ярих бичих, илтгэх, сэтгэх хэрэглээний бүрэн ур чадвартай болгох хэрэгцээнд нийцүүлэн сургалтыг зохион байгуулах” 6-р зорилтын хүрээнд сургууль бүр олон ажлыг зохион байгуулсан байна. Тариалан, Ахлах 3, Увс эрдэнэ, сургуулиуд хэл яриа хөгжүүлэх хүрээнд хийсэн ажил, тэргүүн туршлагаа бусад сургуулийн менежер, номын санч багш нартай хуваалцлаа. Өндөрхангай ахлах сургуулийн дуу хөгжмийн багш Д.Эрдэнэгэрэл, монгол хэл, бичгийн багш Д.Энхбаяр тэргүүтэй багш сурагчдын баг монгол хэлний багш нарт шүлэгч, яруу найрагч Лу гүн С.Лувсандондовын уран бүтээлийг сурталчлах, түүний шүлэг яруу найрагаар дамжуулан хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх, нутгийн яруу найрагчдаа сурталчлах, түүнийгээ орон нутаг бүтээн байгуулалтайгаа холбосон тэргүүн туршлагаа түгээн дэлгэрүүлж, бүтээлийн ном, CDгарган оролцогчдод хэрэглэгдэхүүн болгон түгээсэн нь бусдад үлгэр болохуйц туршлага, шинэ санаа байсан.</p> <p>-Ахлах 3 сургуулийн бага боловсролын багш нар хүүхдийн хэл яриа хөгжүүлэх чиглэлээр хийсэн ажлаа сургалтын менежерүүд болон номын санч, боловсролын газрын мэргэжилтнүүдэд үзүүлж тайлагнасан. Хэл яриа хөгжүүлэх хүрээнд “Индэр” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж хүүхэд бүр хуруун болон хормогчин хүүхэлдэй ашиглан илтгэх чадвараа хөгжүүлсэн байгаа нь давуу байлаа.</p> <p>Увс эрдэм сургуулийн хувьд</p> <ol style="list-style-type: none"> 1. Ширээний хүүхэлдэй 2. Хуруун хүүхэлдэй 3. Хормогчин хүүхэлдэй <p>Утсан хүүхэлдэй гэсэн 4 чиглэлээр бага ангийн сурагчдыг хөгжүүлсэн байна. Өөрийгөө илэрхийлэх болон дүрд хувирах чадвар нь илүү хөгжсөн байгаа нь хүүхдүүдийн үйл ажиллагаанаас харагдаж байна. Аймгийн төвийн сургуулийн бага ангийн сурагчдын дунд хуруун хүүхэлдэйн уралдааныг зохион байгуулж явууллаа.</p>	100%
5.	Үдийн цайны дараа 1-5 ангийн сурагчдад “Ам зайлах” орчныг бүрдүүлэх	<p>Үдийн цай хөтөлбөрийн чанар үр өгөөж хэрэгжилтэд хяналт хийхээс гадна үдийн цайны дараа 1-5 ангийн сурагчид “Ам зайлах” орчин бүрдүүлэх ажлыг хийж, эхэлснээр үдийн цайны дараагаар содтой болон жамц давстай усаар амаа зайлдаг жишиг тогтсон. Наранбулаг, Зүүнхангай, Өндөрхангай, Увс эрдэм сумын сургуулийн хувьд ам зайлах орчин бүрдсэн. Сурагчид шүдээ өдөр үдийн цайны дараа тогтмол угаадаг болсон. Эцэг эхийн оролцоог дэмжсэн олон ажлыг хамтран зохион байгуулсан байна. Малчин сумын сургуулийн хувьд хүүхдийн гар угаалтуурын тусгай өрөөтэй. Францын хөрөнгө оруулалтаар ариун цэврийн өрөө болон гадна био ОО-ыг хийсэн</p>	70%
Зорилт-3- 2. Хүүхдийн авьяас, чадварыг нээн хөгжүүлэх, тэдэнд дэмжлэг үзүүлэх			100%
1.	Сургууль бүр дугуйлан, секц, сонгон хичээллүүлэх орчин бүрдүүлэх	<p>Сургууль, цэцэрлэгүүд “Нэг багш- нэг дугуйлан” аяны санаачлан зохион байгуулж байгаа бөгөөд аяны хүрээнд багш 7 хоногт 2-оос доошгүй цагийг хүүхдийн авьяас хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах удирдамж гарсан. 2016-2017 оны хичээлийн жилд ЕБ-ын 30 сургууль нийт 360 гаруй секц, дугуйлан хичээллэж нийт сурагчдын 60% буюу 10500 гаруй хүүхэд хамрагдсан байна. Энэ нь өмнө оноос 8.5%-аар нэмэгдсэн үзүүлэлт юм.</p>	70%

2.	Олимпиадыг зохион байгуулах удирдамж боловсруулж сургууль, цэцэрлэгүүдэд хүргүүлэх	2017 оны 03-р сарын 29-ний өдрөөс 04-р сарын 02 өдрүүдэд Увс аймгийн Улаангом суманд Улсын төрөлжсөн олимпиадын 2-ын давааг Цогцолбор 1-р сургууль, Цогцолбор 2-р сургууль, Ахлах 3-р сургууль, Ахлах 4-р сургууль, Улаангом политехник коллеж зэрэг сургуулиуд дээр амжилттай зохион байгууллаа. Олимпиадад 24 сургуулийн давхардсан тоогоор 1184 багш нар оролцлоо. Үүнд төрөлжсөн олимпиадад 642 багш, БСУГ-аас зохион байгуулдаг нэрэмжит олимпиадад 542 багш нар оролцсон байна.	100%
3.	22 төрлийн олимпиадыг 2 жил тутамд ээлжлэн зохион байгуулна	2016-2017 оны хичээлийн жилд зохион байгуулсан хүүхэд нэг бүрийг хөгжүүлэгч анги нийтийн олимпиадыг авьяасын 5 мэдрэмжид тулгуурлан 11 нэр төрлийн хичээлээр зохион байгуулж олимпиадад 238 бүлгийн 5345 сурагчид хамрагдлаа. Анги нийтийн олимпиад нь зорилго нь сурагчдын сургалтын чанарыг сайжруулах, хүүхэд нэг бүрийн ахиц амжилтын ахиулах чиглэлээр зохион байгуулагддаг билээ. Сүүлийн 3 жилийн харьцуулсан дүнгээр харахад - Харьцангуй тогтвортой байгаа Чандмань-Эрдэм, Цогцолбор 2, Ахлах 3, Тэс, Бөхмөрөн, - Өмнөх жилийн амжилтаас буурч байгаа үзүүлэлттэй Цогцолбор 1, Ахлах 4, Увс-Эрдэм, Зүүнхангай, Малчин, Өлгий, Хяргас сумын сургуулиуд, - Байрын зөрүү ихтэй Хяргас, Завхан сумдын сургуулиуд, - Хойгуур байруудад тогтвортой байгаа Тариалан, Наранбулаг, Зүүнговь, Өндөрхангай сумын сургуулиудын удирдлагууд багш нараа чадваржуулж, хүүхэд бүрийг хөгжүүлэх, сурагчдын сурлагын чанарт ахиц гарган бүтээлчээр ажиллах шаардлагатай байна. 2016-2017 оны анги нийтийн олимпиадын гүйцэтгэлийн дундаж оноо 40,50% шалгагдсан ба дараа жилийн босго оноог 60 хувиас дээш оноотой байхаар 2017-2018 оны аймгийн зорилтод орууллаа.	100%
Зорилт- 3.3. Хүүхдийн хөгжлийг дэмжсэн орчин бүрдүүлэх			70%
1.	“Монгол зан үйлийн амьдрах ухааны өргөө” танхимын төсөл боловсруулах	“Боловсролын хөгжлийн багц хөтөлбөр”-ийн “Хүүхдийн хөгжил” дэд хөтөлбөрийн хүрээнд ЕБС-ийн дотуур байранд “Монгол зан үйлийн өргөө” байгуулахаар тусгагдсан байгаа. Энэ өргөө байгуулах удирдамж, хөтөлбөрийг боловсруулж сургуулиудад хүргүүлсэн. 2016-2017 оны хичээлийн жилд дотуур байр, сургуулийн хичээлийн байранд Монгол зан үйл, амьдрах ухааны өргөө байгуулсан 15 сургууль, монгол зан үйл, амьдрах ухааны булан байгуулсан 25 цэцэрлэг байна.	100%
2.	Хүүхдийн хийсэн бүтээлийг сурталчлах ажлыг сургуулиуд зохион байгуулах, хүүхдүүдийн дунд бүтээлийн уралдаан зохион байгуулах	Жил бүрийн 5-р сард аймгийн Засаг даргын нэрэмжит “Авьяас” уралдааны үеэр тухайн уралдааны “Б” төрөл болох уран баримал, уран зураг, макет, уран хатгалмалын төрлүүдээр бүтээлээ ирүүлсэн сурагчдаас шагналт байранд шалгарсан сурагчдын бүтээлээр үзэсгэлэн гаргаж, дуудлага худалдаа зохион байгуулдаг. Энэхүү үйл ажиллагааг сургууль дээр зохион байгуулах, хүүхдийн бүтээлийг худалдан борлуулах, сурталчилах үзэсгэлэн, худалдааны өрөө байртай болгох чиглэлд аймгийн хөдөлмөр, халамж, үйлчилгээний газартай хамтран санал боловсруулан ажиллаж байна.	40%
Дундаж үнэлгээ			91,1%

Биелэлтийг нэгтгэсэн: И.Ганболд БСУГ-ын ахлах мэргэжилтэн

Биелэлтийг хянасан: И.Дашням БСУГ-ын дарга

2017 оны 11 сарын 20